



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/89

Батноров сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2025 оны А/265 тоот захирамж, сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүн нарын албан үүргээ биелүүлэх нөхцөлийг сайжруулах, хөдөлмөр хамгаалал, сургалт, дадлага явуулахад шаардлагатай тусгай зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах зардалд 2.758.000 (Хоёр сая долоон зуун тавин найман мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Тусгай зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах зардал болох 2.758.000 (Хоёр сая долоон зуун тавин найман мянган) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү албаны нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Бямбацог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



ОТГОНБАЯР

2025.05.17